ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ

E-NEWSLETTER

facebook.com/Rtcc.m0n
http://rtcc.mrtd.gov.mn
info@rtcc.mrtd.gov.mn
+976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2022 оны 7 дугаар сарын дугаар

"Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн статистик мэдээллийг эхний хагас жилийн байдлаар нэгтгэн боловсруулж албан бичгээр төрийн захиргааны төв байгууллагат хүргүүлж ажилласан.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээллийн нэгдсэн санд хоногийн 1085, 7 хоногийн 56, сарын 70, улирлын 40 мэдээ бүрдүүлэн хөтлөж, боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.



2022 оны 6 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч, ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа зэргээр дүн шинжилгээ хийж, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ. Ачаа тээврийн статистик мэдээг Чингэлэг тээвэрлэлт, тээвэрлэсэн ачаа, ачаа илгээлт, зогчигч тээвэрлэлтээр сар бүр гарган ЗТХЯ-ны сайдын шуурхай хуралд тогтмол танилцуулан ажиллаж байна.

Суурь бүтэц эзэмшигчдийн тээврийн үзүүлэлтүүдийг харуулсан мэдээ бэлтгэн төвийн viber хуудсанд байршуулан ажилласан.

Галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, тайлан мэдэг танилцуулах

Суурь бүтэц хоорондын 2022 оны 2-р улирлын галт тэрэг, вагон солилцоонд дүн шинжилгээ хийж 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн албан бичгээр "УБТЗ" ХНН, "МТЗ" ТӨХК, "БТЕГ" ХХК-д хүргүүлсэн. Нэгдсэн зурмагийн гүйцэтгэлд хилийн галт тэрэг солилцоо, суурь бүтэц хоорондын галт тэрэг, вагон солилцоо, хөдөлгөөний зурмагийг тасалдал, нүүрс, төмрийн хүдэр, зэсийн ачилт үзүүлэлтээр дүн шинжилгээг сард 2 удаа хийж олон нийтийн сүлжээнд байршуулан мэдээллээр ханган ажиллаж байна. 2022 оны 06-р сар, 2 дугаар улирлын галт тэрэгний хөдөлгөөний зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж төрийн захиргааны төв байгууллагат хүргүүлсэн.





Хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгож, мэдээллийн нэгдсэн сан хөтөлж ажиллаж байна.

“Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”-д заасны дагуу ГТХЗНТ нь хөдлөх бүрэлдэхүүнд дугаар олгож, мэдээллийн нэгдсэн сан хөтөлж ажилладаг. Төвийн захирлын тушаалаар өмчлөгчийн 24 кодыг “Хэттрик ложистик” ХХК-д, өмчлөгчийн 25 кодыг “Ар цахир ресурс” ХХК-д, өмчлөгчийн 26 кодыг “Хос карбон” ХХК -д, өмчлөгчийн 27 кодыг “Говийн олон овоо” ХХК-д, өмчлөгчийн 28 кодыг “Суман хээр” ХХК-д, “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-д 1 хагас вагонд шинээр дугаар тус тус олгосон. “Хэттрик ложистик” ХХК-ийн 100 тавцант вагон, “Хос карбон” ХХК-ийн 50 тавцант вагон, “Моншике” ХХК-ийн 50 тавцант вагон, “Говийн олон овоо” ХХК-ийн 100 тавцант вагоны дугаарыг баталгаажуулсан.



Мөн түрээсийн 15 цистерн вагон, “Жи ар капитал логистик” ХХК-ийн 81 тавцант вагон, 1 цистерн вагон, “Дулаан винг” ХХК-ийн түрээсийн 11 тавцант вагон, “Вагон худалдах, худалдан авах гэрээ”-г үндэслэн “Илинк Жэй Ви ложистик” ХХК-ийн 50 тавцант вагоныг хассан, “Суман хээр” ХХК-ийн нэр дээр 50 тавцант вагоныг шилжүүлэн мэдээллийн нэгдсэн санд тус тус бүртгэсэн.

Төслийн багийн хийж гүйцэтгэж буй ажлуудаас:

"КОЙКА-гийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газартай хамтран төвийн барилгын зураг төслийн ажил хийж гүйцэтгэх байгууллага сонгон шалгаруулах тендер зарлах ажиллагаанд дэмлэг үзүүлэх ажлын хүрээнд KOTI (Korea transport institue) компанийн боловсруулсан барилгын зураг төслийн ажлын даалгаварыг КОЙКА монгол хэлрүү хөрвүүлэн илгээсэн. Монгол хэлрүү орчуулсан орчуулга болон даалгаврын орчуулсан Монгол хувилбарт санал боловсруулан тусгасан.

Мөн Койка-тай хамтран хэрэгжүүлэх төсөлтэй холбоотой 7 сард хийж гүйцэтгэсэн ажлын бичиг баримт, тэмдэглэллийг эмхэтгэн боловсруулсан. "ISO 17363:2013 Supply chain applications of RFID - Freight containers" олон улсын стандартыг 90 хувийн гүйцэтгэлтэй орчуулж, техник технологийн мэргэжлийн үг хэллэгийн орчуулгыг хянах ажлыг гүйцэтгэж байна.

Инженер-Ирээдүй хөтөлбөрийн хүрээнд магистрын сургалт үргэлжилж байна.

ОХУ-ын Эрхүү хотын зам харилцааны улсын их сургуультай 3 дахь жилдээ магистрын эчнээ сургалтыг зохион байгуулж байна. Энэ жилийн магистрын элсэлтийн бүртгэл 05 дугаар сараас 8 дугаарс сар хүртэлх хугацааг хамарсан бөгөөд нийт 16 инженерийг бүртгээд, материалыг нь бүрдүүлэн ИрГУПС-ын сургалтын албанд цахимаар илгээсэн.

Энэхүү магистрын хөтөлбөрт төмөр замын салбарт ажиллаж байгаа инженерүүдийг хамруулж байгаа бөгөөд 5 жил үргэлжлэх юм. 5 жилийн хугацаанд нийт 40-50 инженерийг хос дипломтой болгохоор зорилт тавин ажиллаж байна. Одоогийн байдлаар 20 инженер суралцаж байна.

СТАТИСТИК

/2022 оны 06 дугаар сарын байдлаар/

Төмөр замын тээврийн үндсэн үзүүлэлт



2022 оны зургаадугаар сард 2012.6 мян.тн ачаа тээвэрлэсэн байна.

Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/



2022 оны зургаадугаар сард 188.7 мян.тн ачаа дамжин өнгөрсөн байна.

Ачилт - ачааны төрлөөр

/2022 оны 06 дугаар сард/



Ачилтаар 2022 оны зургаадугаар сард нийт 1459.0 мян.тн ачсан ба үүнээс нүүрс, төмрийн хүдэр 960.6 мян.тн ачсан байна.

Нүүрс	37.1%
Төмрийн хүдэр	28.6%
Бусад ачаа	2.9%
Барилгын материал	18.6 %
Жонш	3.1%
Зэс, молибдений баяжмал	3.4%
Нефтийн бүтээгдэхүүн	1.8%

2022 оны 06 дугаар сард өссөн дүнгээр 12661.9 мян.тн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс -20.5% буурсан үзүүлэлттэй байна.

ИНФОГРАФИК

Зорчигч тээвэрлэлт /мян.зор/
/өссөн дүнгээр/

	2021он	2022он
Олон улс	0.0	2.5
Орон нутаг	0.0	1043.3

Зорчигч эргэлт /сая.зор-км/

2021он	2022он
0.0	303.6

Дамжин өнгөрсөн ачаа /мян.тн/
/өссөн дүнгээр/

2021 /06 сар/	2022 /06 сар/
1524.9 мян.тн	2183.5 мян.тн

Суурь бүтэц эзэмшигчээр /тээвэрлэсэн ачаа/
/өссөн дүнгээр/

Төмрийн хүдэр	Төмрийн хүдэр	Бүх төрлийн ачаа
189433.4 мян.тн	1181.2 мян.тн	12661.9 мян.тн

Тээвэрлэсэн ачааны мэдээ /мян.тн/
/өссөн дүнгээр/

	2021	2022
Экспорт	5938.6	3430.0
Импорт	1665.5	1913.0
Дамжин өнгөрөх	2183.0	1525.0
Орон нутаг	6142.7	5793.9

2022 /06 сар/ - 12661.9 мян.тн

Нүүрс	Төмрийн хүдэр	Бусад төрөл ачаа
57.6%	17.2%	2.0%

Галт тэрэгний зурмагийн биелэлт
/өссөн дүнгээр/

Суудал г/т	2021	2022		2021	2022	Ачааны г/т
	0	2836	Өнгөрүүлэлт	25668	19932	
	0	2880	Явуулалт	31807	24595	

Зорчигчийн галт тэрэг явуулалтаар 2889 г/т төлөвлөснөөс 2880г/т явуулж биелэлт 99,7% ,өнгөрүүлэлтээр 2877 г/т төлөвлөснөөс 2836 г/т өнгөрүүлж биелэлт 98.6%, ачааны галт тэрэг явуулалтаар 24652 г/т төлөвлөснөөс 24595 г/т явуулж биелэлт 99.8%, өнгөрүүлэлтээр 19932 г/т төлөвлөснөөс 19645 г/т өнгөрүүлж биелэлт 98.6% болсон байна.

Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс